



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар A/207

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд эзэмшүүлэх газрыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч байгууллага болох Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд даалгасугай.

3. Газар эзэмшилтэд байнгын хяналт тавьж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг сумын газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.



Б.ЭРДЭНЭБААТАР



сумын Засаг даргын 2024 оны
11 дугаар сарын 08-ны өдрийн
А/2024 дугаар захирамжийн хавсралт

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Газрын зориулалт	Эзэмшүүлэх хугацаа /жил/	Газрын нэр	Төлөвлөлтийн н нэгж талбар	Баг	Газрын хэмжээ /га/
1	Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	9081208	Төрийн байгууллага	15	Хангалын цоргот	3901865	2-р баг, Баянзүрх	2
Дүн								2